



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БОР-ӨНДӨР СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 5/13

Бор-өндөр сум

┌ С.Рагчаасүхийг нийгмийн эрүүл мэнд, ┐  
эрүүл ахуйчаар томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 48 дугаар зүйлийн 48.1, 50 дугаар зүйлийн 50.1, Засгийн газрын 2019 оны “Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Нэгдсэн эмнэлгийн даргын 2022 оны “Эмч, ажилчдын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 0/26 тоот тушаал, Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт, Эрүүл мэндийн сайдын 2018 оны “Эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчдын хоол унааны хөнгөлөлт, нэмэгдэл, урамшлын хэмжээг тогтоох тухай” А/548 тоот тушаал, 2020 оны “Хамтын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах тухай” А/69 дугаар тушаал, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сүхбаатарын Рагчаасүхийг 2023 оны 01 дүгээр сарын 19-ны өдрөөс эхлэн нийгмийн эрүүл мэнд, эрүүл ахуйчаар томилон ажиллуулсугай.
2. С.Рагчаасүхийг 2023 оны 01 дүгээр сарын 19-ны өдрөөс эхлэн ТҮЭМ5-1 шатлалаар тогтоон үндсэн цалинг 915.593 (есөн зуун арван таван мянга таван зуун ерэн гурав), хоолны мөнгө өдрийн 3000 (гурван мянга), Орон нутагт ажилласны нэмэгдэл цалингийн 15% 137.339 (зуун гучин долоон мянга гурван зуун гучин ес) төгрөгөөр тус тус тооцож олгохыг Нягтлан бодогч (Т.Эрдэнэболор)-т зөвшөөрсүгэй.
3. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ёс зүйн хэм хэмжээг мөрдөн ажиллахыг (С.Рагчаасүх)-д үүрэг болгосугай.

ДАРГА  А.БАТБААТАР

